

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 02 дугаар сарын 19

Номгон

Аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлого нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн стратеги төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон хүний нөөцийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр болон нутгийн захиргааны байгууллагуудын бусад хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

Нэг. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах 2022 оны ололт, амжилтыг нэгтгэн дүгнэж, зөрчил дутагдлыг хэлэлцэн 2023 онд дэвшүүлэн тавьж буй зорилго, зорилтыг харилцан санал солилцон сайжруулахаар аймгийн “Хот, хөдөөгийн сэргэлт зөвлөгөөн”, “Төрийн байгууллагуудын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”, Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны нэгдсэн зөвлөгөөн, Улс төрийн албан тушаалтныг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн, Төрийн албаны ёс зүй, хандлага соёлын шинэтгэл” сэдэвт сургалт, зөвлөгөөн, спортын бага наадмыг зохион байгууллаа.



Зураг дээр: “Төрийн байгууллагуудын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”- 2023 он

Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хот хөдөөгийн тэнцвэрт бус хөгжлийг гал унтраах байдлаар бус цогцоор нь шийдвэрлэхээр “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн бодлогыг хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Энэ хүрээнд орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэхэд чиглэгдсэн шинэ санаачилга, хөрөнгө оруулалт, томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. Зөвлөгөөний үеэр Улаанбаатараас орон нутагт шилжин суурьших иргэд, ААНБ-ыг дэмжихэд Баянхонгор аймгийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, нийгэм, эдийн засгийн бодит үнэлэмж, үйлдвэрлэл үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зэрэг ямар нөхцөл боломж байгааг иргэд олон нийтэд хүргэх,

сурталчлах, тэдгээрт үзүүлэх дэмжлэгийн талаар багтаасан “НЭЭЛТТЭЙ БАЯНХОНГОР” хөтөлбөрийг аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан танилцуулав.



Зураг дээр: Нээлттэй Баянхонгор сургалт, зөвлөгөөн

Засаг захиргааны анхан шатны нэгж болох багийн Засаг дарга нарт Монгол Улсын хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулах, багийн иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг чанаржуулж, харилцан хамтран ажиллах агуулгын хүрээнд аймгийн ЗДТГ-аас 20 сумын Засаг даргын орлогч, 105 багийн дарга нарын дунд нэгдсэн сургалт, семинарыг зохион байгуулав. Сумдын орлогч дарга болон багийн дарга нар Монгол Улсын урт хугацааны бодлого шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргийн нөхцөл байдал, нийгмийн салбарын анхаарах асуудал, иргэний болон хөрөнгийн бүртгэл, гэр бүл, хүүхэд залуусын талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, ХАА, мал эмнэлгийн чиглэлээр анхаарах асуудал, архив, албан хэрэг хөтлөлт, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, цэргийн бүртгэл, статистик-ын талаар цогц мэдээллээр хангагдаж, өөрийн хариуцсан баг хорооныхоо үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх болно.



Зураг дээр: 20 сумын засаг даргын орлогч, 105 багийн дарга нарын дунд сургалт семинар

Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор "Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба" аяныг 2023 оны 03 дугаар сарын

15-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулав.

Аяны хүрээнд:

1. “Төрийн албаны эрх зүйн шинэчлэл” сэдэвт сургалт зохион байгуулах;
2. “Төрийн алба-цахимжилт” Төрийн албаны Хүний нөөцийн систем хөтлөлтийг сайжруулах;
3. “Төрийн албаны шинэтгэл- Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт Төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулав.

“Төрийн албаны ёс зүй, хандлага соёлын шинэтгэл” сэдэвт сургалт, зөвлөгөөн, спортын бага наадмыг аймгийн Засаг даргын тамгын газар, 20 сумын Засаг даргын Тамгын газрын 500 орчим төрийн албан хаагчдыг хамруулан 2 өдрийн турш зохион байгуулж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 25.5 сая төгрөгийг зарцууллаа.



Зураг дээр: “Төрийн албаны ёс зүй, хандлага соёлын шинэтгэл” сэдэвт сургалт, зөвлөгөөн, спортын бага наадам

Төрийн Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэлтийг танилцуулах, сурталчлах, шинэчлэл өөрчлөлтийг нэтрүүлж, ажлын хариуцлага, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Баянхонгор аймгийн ЗДТГ-аас Төрийн архивын тасагтай хамтран “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэлт - өөрчлөлт” нэгдсэн зөвлөгөөнийг Баянхонгор аймгийн 200 гаруй төрийн байгууллагын архив, албан хэргийн ажилтнуудыг оролцуулан зохион байгуулав.



Зураг дээр: “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэлт - өөрчлөлт” нэгдсэн зөвлөгөөн

Баянхонгор аймгийн бодлогын баримт бичиг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор АЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлаг, Төрийн болон орон нутгийн өмчит 10 байгууллагын удирдлага, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний дунд зохион байгуулсан.



Зураг дээр: “Төрийн бүтээмж ба үнэлгээ, мониторинг” сургалт

Австралийн Засгийн Газар, “Healthy Land and Water” олон улсын төрийн бус байгууллагаас “Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг Монгол орны усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөлтөд тусгах нь” сэдэвт манлайллын хөтөлбөрт Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 2 албан хаагч хамрагдлаа.



Зураг дээр: “Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг Монгол орны усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөлтөд тусгах нь” сэдэвт манлайллын хөтөлбөрт хамрагдсан албан хаагчид

БНХАУ-ын Ганьсү мужийн Жючуан хотод хөдөө аж ахуйн технологийг сурталчлах үйлчилгээний төв, ойн жимсний үйлчилгээний төвд нарны хүлэмжийн технологи, органик бордоо боловсруулах технологи, ой мод тарих технологи гэсэн 3 чиглэлээр наран хүлэмжийн аж ахуйн техникчээр 3 хүн, бордоо бэлтгэх техникчээр 2, ой мод үржүүлгийн технологичоор 1 нийт Баянхонгор аймгийн холбогдох 6 мэргэжилтнийг 20 хоногийн хугацаанд туршлага судлуулав.



Зураг дээр: БНХАУ-ын Ганьсү мужийн Жючуан хотод туршлага судалж байна.

Бүгд найрамдах Солонгос улсын Сүүл хотын SOON CHUN HYANG UNIVERSITY HOSPITAL эмнэлэгт Баянлиг сумын эрүүл мэндийн төвийн сувилагч С.Энхтэгш, Оточмандал өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч Ш.Ариунаа, Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн эх баригч бага эмч Д.Баярхүү нийт 3 албан хаагчийг, Өвөр Монголын өөртөө засах орны “Монгол, Хятад эмнэлэг”-т мэргэшил дээшлүүлэх гадаад сургалтад Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн арга зүйч Г.Баярмааг, эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Хөх хотод зохион байгуулсан чадавхжуулах сургалтад багийн 10 эмчийг хамруулсан.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүдийг БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах оронд зохион байгуулагдсан "Монголын хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хяналт шалгалтын технологи" сэдэвт 21 хоногийн чадавхжуулах сургалт, БНСУ-д "Хүнсний аюулгүй байдал болон загас үржүүлгийн технологи" сэдэвт 7 хоногийн чадавхжуулах сургалтад хамруулав.



Зураг дээр: Сургалтад хамрагдсан албан хаагчид

Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 8, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 11, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 16, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 7, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагчийг тус тус улсын төсвийн зардлаар, мөн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц төлбөртэй сургалтад 16 албан

хаагчийг суралцуулж нийт 26,240,000 төгрөгийн төлбөрийг тухайн байгууллагын зардлаас санхүүжүүлж сургалтад хамруулсан.


Хоёр. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2,104,997.761 төгрөгийн санхүүжилтийг тус тус шийдвэрлэсэн байна.

Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс Улсын Их Хурлын “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” батлах тухай 21 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох болзол шаардлагыг хангасан 23 байгууллагын 122 төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, саналыг аймгийн Засаг даргад уламжилж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байдал:



Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг үндэслэн, Төрийн албаны тухай хуулийн 22, 27, 28, 31 дүгээр зүйлд тавигдсан шаардлага, нөхцөл болзлыг хангаж, төрийн албаны шалгалтад тэнцэн, тухайн албан тушаалд туршилтын хугацаанд ажиллахдаа төрийн албан хаагчийн зорилго, зорилт, чиг үүргээ мэргэжил ур чадварын зохих түвшинд амжилттай гүйцэтгэж байгаа төрийн

захиргааны 15 байгууллага, 10 сумын нийт 70 албан хаагчаар “Төрийн албан хаагчийн тангараг” өргүүлэх ёслолын ажиллагааг зохион байгууллаа.



Зураг дээр: “Төрийн албан хаагчийн тангараг” өргүүлэх ёслолын ажиллагаа

Сумдын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр:

“Тэргүүний сум”-аар Баян-Овоо сум шалгарч 7,2 сая, дэд байранд Баянхонгор сум орж 4,800 сая, “Гутгаар” байранд Бууцагаан сум орж 2,4 сая тусгай байрт Өлзийт, Эрдэнэцогт сумдууд шалгарч 1,2 сая төгрөгөөр тус тус шагнуулсан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр: “Тэргүүний байгууллага” –аар Биеийн тамир, спортын газар шалгарч 4,8 сая, “Дэд” байранд Хүнс, хөдөө аж ахуйн газар шалгарч 3,0 сая, “Гутгаар” байранд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албан шалгарч 1,8 сая, тусгай байранд Онцгой байдлын газар, Татварын хэлтэс нар шалгарч 600,000 мянган төгрөгөөр шагнуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр:

Тэргүүн байранд Санхүү төрийн сангийн хэлтэс шалгарч 1,8 сая, Дэд байранд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс шалгарч 1,2 сая төгрөгөөр шагнагдсан.

Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр:

Тэргүүн байранд “Чандмань-Баянхонгор” ХК, дэд байранд “Цэвэр хот” ОНӨААТҮГ, тусгай байранд Баянхонгор эрчим хүч ЦТХХК шалгарч, шагнагдсан байна.



Зураг дээр: Шагнагдсан сум, байгууллагын албан хаагчид

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2022 онд хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн үнэлгээгээр манлайлж Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Д.Сарангарав даргатай Хууль, эрх зүйн хэлтэс Тэргүүн байранд шалгарсан тул 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгөөр шагнаж урамшуулав.



Зураг дээр: Хууль зүй, дотоод хэргийн сайдын батламж, өргөмжлөл


Төрийн байгууллагад тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан 2 албан хаагчийг “Төрийн албаны Тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, төрийн одон медалиар 40 гаруй албан хаагчийг, салбарын болон аймгийн шагналаар 70 гаруй албан хаагчийг тус тус шагнаж урамшууллаа.

Байгууллагын 2023 онд хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн үнэлгээгээр манлайлан ажилласан Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс мөн 15 албан хаагчийг шагнаж урамшуулав.



Зураг дээр: 2023 оны шилдэг албан хаагчид

Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай мэргэжлээр эмч сувилагч нарыг сургах ажлын хүрээнд 10.0 сая төгрөг зарцуулан, 3 чиглэлээр 11 эмч, мэргэжилтнийг сургахаар болж, сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэв.



Зураг дээр: Сургалтын төлбөрийн дэмжлэг авсан мэргэжилтнүүд

Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан тул байгууллагаас үйл ажиллагаандаа ашиглаж байсан, ашиглахаар төлөвлөсөн байсан автомашинуудыг аймаг орон нутагт хүлээлгэн өгч, хүн ардын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай сумдад хүлээлгэн өглөө.



Зураг дээр: Автомашин гардуулах үйл ажиллагаа

Мэргэжлийн урлагийн байгууллага, сумдын соёлын төвийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх хүрээнд соёлын салбарт шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийлээ.



Зураг дээр: соёлын салбарт шаардлагатай тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх үйл ажиллагаа УИХ-ын дарга Г. Занданшатарын санаачилгаар хэрэгжүүлж буй бүх багш нарыг компьютержуулах төслийн хүрээнд Баянхонгор аймгийн 600 багшийг компьютер хангаж, улсын төсвийн санхүүжилтээр 1,6 тэрбум төгрөгийг зарцуулав.



Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг хангах зорилгоор Хөдөө, аж ахуйн их сургууль, Аймгийн Засаг дарга, Сумын Засаг дарга, суралцагч нар хамтарсан гэрээ байгуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр оюутны сургалтын

төлбөрийн 50 хувийг дааж дэмжлэг үзүүлсэн. 2022-2023 оны хичээлийн жилд агрономич 1, малын их эмч 2, мал зүйч буюу зоотехникчээр 16 оюутан нийт 19 оюутан суралцуулж, шаардлагатай байгаа хүний нөөцийг бэлтгэн ажиллаж байна.

Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2023 оноос орон нутгийн нэмэгдлийг төрийн захиргааны албан хаагчдад 20 хувиар олгов.

Тайлант онд төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан нөхөх төлбөр 639,818,036 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан тусламжид 490,370,784 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан нийтлэг баталгаанд 97,480,8941 сая төгрөгийг зарцуулсан байна.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

П.ОТГОНБАЯР

ТАЙЛАГНАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНЖАРГАЛ

Мэдээллийг пэлгэрүүлж авах албан хаагчийн мэдээлэл:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Д.Отгонжаргал

Холбоо барих утас: 70443486